**ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

# Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ХӨА-2024/203/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Мөрөн сум<br>2024 он | Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар<br>Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn<br>Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр<br>Утас: 99089114 Цахим хаяг:tegshdelgerb@audit.gov.mn<br>Аудитор: Г.Ичинхорлоо<br>Утас:88688168 Цахим хаяг: ichinkhorloog@audit.gov.mn<br>Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа<br>Утас:99389208 Цахим хаяг: b_myadagmaaa@yahoo.com<br>Аудитор Ц.Мөнхтуяа<br>Утас: 99382220 Цахим хаяг: munkhtuya2220@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.02.26 № 01/151

танай ______-ны № ______-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ТОСОНЦЭНГЭЛ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ О.ДААРИЙМАА ТАНАА

**Хараат бус аудиторын дүгнэлт**

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх мөнгөн хөрөнгийн данс 154,811.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

**Аудитын гол асуудал**

Аудитаар зардлыг зориулалт, арга хэмжээний дагуу зарцуулаагүй, нэмэгдэл хөлс илүү тооцож олгосон, малын үнэлгээ, сурах бичгийн түрээсийн тооцоо, олон улсын байгууллагаас хандивласан хөрөнгийн бүртгэлтэй холбоотой нийт 30,493.6 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг илрүүлснээс, 25,484.0 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 4,202.2 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 807.4 мянган төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлсэн

**Бусад асуудлын хэсэг**

Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2023 онд "Сайн туршлагаа түгээн дэлгэрүүлэх, хамтран суралцах үйл явцыг идэвхжүүлэн, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээнд суурилсан хөгжил, оролцооны арга зүйг хэрэгжүүлнэ" зорилгын хүрээнд 8 зорилт дэвшүүлж, 89.8 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

6724040263

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **223,931,911.41** | **356,249,553.20** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **39,010,469.52** | **154,811,415.26** |
| **31200** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **39,010,469.52** | **154,811,415.26** |
| **31210** | **Төгрөг** | **39,010,469.52** | **154,811,415.26** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 39,010,469.52 | 154,811,415.26 |
| **33** | **АВЛАГА** | **29,207,894.00** | **10,808,430.02** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 0 | 8,098,936.02 |
| **33500** | **Бусад авлага** | **29,207,894.00** | **2,709,494.00** |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 26,758,000.00 | 0 |
| 33520 | Хувь хүмүүсээс авах авлага | 2,449,894.00 | 2,709,494.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **155,713,547.89** | **190,629,707.92** |
| **35100** | **Түүхий эд материал** | **173,250.00** | **500,000.00** |
| 35130 | Эм боох материал | 173,250.00 | 500,000.00 |
| **35400** | **Хангамжийн материал** | **154,650,297.89** | **189,637,307.92** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,144,000.00 | 2,036,650.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 41,774,854.02 | 43,546,924.02 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 5,824,900.00 | 4,400,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 32,076,326.00 | 37,302,409.50 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 72,830,217.87 | 102,351,324.40 |
| 35600 | Мал амьтад | 890,000.00 | 492,400.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **4,188,122,112.36** | **4,058,325,993.17** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **4,188,122,112.36** | **4,058,325,993.17** |
| 39100 | Газар | 0 | 0 |
| **39200** | **Биет хөрөнгө** | **4,101,884,112.36** | **3,972,261,243.17** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 4,087,069,763.64 | 4,087,069,763.64 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -407,346,284.70 | -523,640,401.38 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 232,120,055.00 | 301,755,265.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -80,606,324.11 | -131,301,240.66 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 140,396,217.80 | 159,699,389.80 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -42,914,951.90 | -59,601,693.56 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 264,551,803.25 | 264,451,803.25 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -125,998,076.78 | -169,146,653.38 |
| 39217 | Ном | 34,611,910.16 | 42,975,010.46 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **86,238,000.00** | **86,064,750.00** |
| 39301 | Програм хангамж | 1,155,000.00 | 1,155,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -231,000.00 | -404,250.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 85,314,000.00 | 85,314,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **4,412,054,023.77** | **4,414,575,546.37** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **2,300,776.00** | **101,919.24** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **2,300,776.00** | **101,919.24** |
| **41300** | **Өглөг** | **2,300,776.00** | **101,919.24** |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 0 | 101,919.24 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 2,300,776.00 | 0 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **4,409,753,247.77** | **4,414,473,627.13** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **4,409,753,247.77** | **4,414,473,627.13** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 976,754,083.81 | 976,754,083.81 |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 976,754,083.81 | 976,754,083.81 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **1,844,302,497.17** | **1,849,022,876.53** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,921,894,029.88 | 1,844,302,497.17 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | -77,591,532.71 | 4,720,379.36 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,588,696,666.79 | 1,588,696,666.79 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **4,412,054,023.77** | **4,414,575,546.37** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,458,063,395.00** | **2,910,112,527.93** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **49,020,395.00** | **62,259,327.93** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **37,872,195.00** | **37,034,927.93** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **7,337,900.00** | **1,974,500.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 7,337,900.00 | 124,500.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 1,850,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 26890670 | 8,054,300.30 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 3643625 | 27,006,127.63 |
| **122** | **Тусламжийн орлого** | **11,148,200.00** | **25,224,400.00** |
| **122001** | **Хандив тусламж /дотоод/** | **11,148,200.00** | **25,224,400.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,409,043,000.00** | **2,847,853,200.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **1,863,547,100.00** | **2,340,686,400.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,863,547,100.00 | 2,340,686,400.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **1,257,400.00** | **-** |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,257,400.00 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **544,238,500.00** | **507,166,800.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 544,238,500.00 | 507,166,800.00 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,533,844,655.19** | **2,905,236,284.47** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,533,844,655.19** | **2,905,236,284.47** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,448,323,235.19** | **2,806,313,543.98** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,341,931,795.77** | **1,623,439,798.45** |
| 210101 | Үндсэн цалин | 947,918,070.82 | 1,141,832,335.94 |
| 210102 | Нэмэгдэл | 321,792,786.95 | 400,104,527.10 |
| 210104 | Урамшуулал | 72,220,938.00 | 81,502,935.41 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **169,003,532.71** | **207,802,013.92** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 116,243,967.00 | 141,907,775.41 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 13,505,481.15 | 16,794,698.27 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 10,747,214.68 | 13,361,404.40 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,591,533.64 | 3,262,719.43 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 25,915,336.24 | 32,475,416.41 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **475,038,664.00** | **469,343,191.75** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 12,497,776.00 | 26,251,491.75 |
| 210302 | Түлш, халаалт | 459,540,888.00 | 441,091,700.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,000,000.00 | 2,000,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **33,805,171.03** | **18,672,435.10** |
| 210401 | Бичиг хэрэг | 4,230,120.00 | 6,283,806.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,171,400.00 | 0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 12,108,238.00 | 11,494,908.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 11,295,413.03 | 893,721.10 |
| **2105** | **Нормативт зардал** | **148,621,599.00** | **156,441,664.50** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 3,198,620.00 | 2,052,640.00 |
| 210502 | Хоол, хүнс | 145,422,979.00 | 154,389,024.50 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **8,150,000.00** | **39,198,700.00** |
| 210604 | Урсгал засвар | 8,150,000.00 | 39,198,700.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **14,817,900.00** | **7,834,500.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,337,900.00 | 124,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 10,480,000.00 | 7,710,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **256,954,572.68** | **283,581,240.26** |

| | | | |
|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 18,623,510.00 | 30,891,574.87 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 11,234,060.00 | 18,189,900.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 227,097,002.68 | 234,499,765.39 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **85,521,420.00** | **98,922,740.49** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **81,324,361.00** | **96,974,808.24** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 80,820,361.00 | 81,367,065.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 504,000.00 | 15,607,743.24 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **4,197,059.00** | **1,947,932.25** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,197,059.00 | 1,947,932.25 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **-75,781,260.19** | **4,876,243.46** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **1,810,272.52** | **155,864.10** |
| 225001 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз | 1,810,272.52 | 155,864.10 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН** | **-77,591,532.71** | **4,720,379.36** |

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **2,416,380,900.00** | **2,849,827,700.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **7,337,900.00** | **1,974,500.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **7,337,900.00** | **1,974,500.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **7,337,900.00** | **1,974,500.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 7,337,900.00 | 124,500.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 1,850,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,409,043,000.00** | **2,847,853,200.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **1,863,547,100.00** | **2,340,686,400.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,863,547,100.00 | 2,340,686,400.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **1,257,400.00** | **-** |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,257,400.00 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **544,238,500.00** | **507,166,800.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 544,238,500.00 | 507,166,800.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,348,691,430.48** | **2,689,203,944.26** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,348,691,430.48** | **2,689,203,944.26** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,263,088,110.48** | **2,582,134,947.57** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,341,931,795.77** | **1,631,711,815.23** |
| 210101 | Үндсэн цалин | 947,918,080.80 | 1,150,104,352.72 |
| 210102 | Нэмэгдэл | 321,792,777.37 | 400,104,527.10 |
| 210104 | Урамшуулал | 72,220,937.60 | 81,502,935.41 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **168,978,239.71** | **207,527,013.92** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 115,513,109.55 | 141,632,775.41 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 13,588,403.48 | 16,794,698.27 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 10,857,202.68 | 13,361,404.40 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,710,215.54 | 3,262,719.43 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 26,309,308.46 | 32,475,416.41 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **473,363,788.00** | **470,219,067.75** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10,197,000.00 | 28,552,267.75 |
| 210302 | Түлш, халаалт | 460,166,788.00 | 439,666,800.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,000,000.00 | 2,000,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **1,332,400.00** | **-** |
| 210402 | Тээвэр, шатахуун | 158,400.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,174,000.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | **173,649,789.00** | **151,348,888.00** |
| 210502 | Хоол, хүнс | 173,649,789.00 | 151,348,888.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **9,000,000.00** | **34,999,800.00** |
| 210604 | Урсгал засвар | 9,000,000.00 | 34,999,800.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **14,817,900.00** | **7,834,500.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,337,900.00 | 124,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 10,480,000.00 | 7,710,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **80,014,198.00** | **78,493,862.67** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 62,779,778.00 | 60,303,962.67 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 17,234,420.00 | 18,189,900.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **85,603,320.00** | **107,068,996.69** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **81,406,261.00** | **105,121,064.44** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 81,406,261.00 | 89,442,693.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 15,678,371.44 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **4,197,059.00** | **1,947,932.25** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,197,059.00 | 1,947,932.25 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **67,689,469.52** | **160,623,755.74** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **28,679,000.00** | **44,822,810.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **28,679,000.00** | **44,822,810.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **28,679,000.00** | **44,822,810.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 28,679,000.00 | 44,822,810.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **-28,679,000.00** | **-44,822,810.00** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **39,010,469.52** | **115,800,945.74** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 39,010,469.52 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 39,010,469.52 | 154,811,415.26 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **976,754,083.81** | **1,588,696,666.79** | **1,921,894,029.88** | **4,487,344,780.48** |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 976,754,083.81 | 1,588,696,666.79 | 1,921,894,029.88 | 4,487,344,780.48 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | -77,591,532.71 | -77,591,532.71 |
| **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **976,754,083.81** | **1,588,696,666.79** | **1,844,302,497.17** | **4,409,753,247.77** |
| **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **976,754,083.81** | **1,588,696,666.79** | **1,844,302,497.17** | **4,409,753,247.77** |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 976,754,083.81 | 1,588,696,666.79 | 1,844,302,497.17 | 4,409,753,247.77 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 4,720,379.36 | 4,720,379.36 |
| **2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл** | **976,754,083.81** | **1,588,696,666.79** | **1,849,022,876.53** | **4,414,473,627.13** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**Улсын төсвийн гүйцэтгэл** / төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь | Зөрүү |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,386,914,500.00** | **2,226,859,954.26** | **93.29** | **160,054,545.74** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,386,914,500.00** | **2,226,859,954.26** | **93.29** | **160,054,545.74** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,269,663,500.00** | **2,121,738,889.82** | **93.48** | **147,924,610.18** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,750,503,800.00** | **1,631,711,815.23** | **93.21** | **118,791,984.77** |
| 210101 | Үндсэн цалин | 1,203,960,600.00 | 1,150,104,352.72 | **95.53** | **53,856,247.28** |
| 210102 | Нэмэгдэл | 466,628,900.00 | 400,104,527.10 | **85.74** | **66,524,372.90** |
| 210104 | Урамшуулал | 79,914,300.00 | 81,502,935.41 | **101.99** | **-1,588,635.41** |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **218,813,000.00** | **207,527,013.92** | **94.84** | **11,285,986.08** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 148,792,800.00 | 141,632,775.41 | **95.19** | **7,160,024.59** |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 17,505,100.00 | 16,794,698.27 | **95.94** | **710,401.73** |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 14,004,000.00 | 13,361,404.40 | **95.41** | **642,595.60** |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,501,000.00 | 3,262,719.43 | **93.19** | **238,280.57** |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 35,010,100.00 | 32,475,416.41 | **92.76** | **2,534,683.59** |
| **2105** | **Нормативт зардал** | **156,528,200.00** | **151,348,888.00** | **96.69** | **5,179,312.00** |
| 210502 | Хоол, хүнс | 156,528,200.00 | 151,348,888.00 | **96.69** | **5,179,312.00** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **16,289,000.00** | **7,834,500.00** | **48.10** | **8,454,500.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,162,400.00 | 124,500.00 | **2.99** | **4,037,900.00** |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 12,126,600.00 | 7,710,000.00 | **63.58** | **4,416,600.00** |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **127,529,500.00** | **123,316,672.67** | **96.70** | **4,212,827.33** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 109,339,600.00 | 105,126,772.67 | **96.15** | **4,212,827.33** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 18,189,900.00 | 18,189,900.00 | **100.00** | **0.00** |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **117,251,000.00** | **105,121,064.44** | **89.65** | **12,129,935.56** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **117,251,000.00** | **105,121,064.44** | **89.65** | **12,129,935.56** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 101,486,400.00 | 89,442,693.00 | **88.13** | **12,043,707.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 15,764,600.00 | 15,678,371.44 | **99.45** | **86,228.56** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **2,386,914,500.00** | **2,342,660,900.00** | **98.15** | **44,253,600.00** |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **2,340,686,400.00** | **2,340,686,400.00** | **100.00** | **0.00** |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 2,340,686,400.00 | 2,340,686,400.00 | **100.00** | **0.00** |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **46,228,100.00** | **1,974,500.00** | **4.27** | **44,253,600.00** |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,162,400.00 | 124,500.00 | **2.99** | **4,037,900.00** |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,070,000.00 | 1,850,000.00 | **60.26** | **1,220,000.00** |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 38,995,700.00 | - | **0.00** | **38,995,700.00** |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 39,010,469.52 | | **-39,010,469.52** |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 154,811,415.26 | | **-154,811,415.26** |

**Орон нутгийн төсвийн гүйцэтгэл** / төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь | Зөрүү |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **507,166,800.00** | **505,218,867.75** | **99.62** | **1,947,932.25** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **507,166,800.00** | **505,218,867.75** | **99.62** | **1,947,932.25** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **507,166,800.00** | **505,218,867.75** | **99.62** | **1,947,932.25** |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **472,166,800.00** | **470,219,067.75** | **99.59** | **1,947,732.25** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 30,500,000.00 | 28,552,267.75 | **93.61** | **1,947,732.25** |
| 210302 | Түлш, халаалт | 439,666,800.00 | 439,666,800.00 | **100.00** | **-** |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,000,000.00 | 2,000,000.00 | **100.00** | **-** |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **35,000,000.00** | **34,999,800.00** | **100.00** | **200.00** |
| 210604 | Урсгал засвар | 35,000,000.00 | 34,999,800.00 | **100.00** | **200.00** |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **507,166,800.00** | **505,218,867.75** | **99.62** | **1,947,932.25** |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **507,166,800.00** | **505,218,867.75** | **99.62** | **1,947,932.25** |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 507,166,800.00 | 505,218,867.75 | **99.62** | **1,947,932.25** |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 245,639.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлсэн. Үүнд:

- Санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 25484 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 25,484.0 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 4,202.2 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 807.4 мянган төгрөгийн 3 зөвлөмжийг хүргүүлсэн.
- Нийцлийн аудитад хамааралтай 215,145.4 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлэв.

Аудитаар нийт 25,484.0 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 25,484.0 мянган төгрөгийн алдааг залруулсан.

Залруулсан алдаа:

- Түрээсийн сурах бичгийн төлбөртэй холбоотой 259.6 мянган төгрөгийн авлагыг бүртгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн “14.4.Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:”, “14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;” гэсэн заалттай нийцэхгүй, “тасалбар болголт” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул залруулга хийсэн.
- Сургуулийн төгсөгчид болон “Тайвань хүүхэд гэр бүлийг дэмжих сан” олон улсын байгууллагаас өгсөн хандив тусламжийн орлогыг системийн дээд байгууллагаас хүлээж авсан үнэ төлбөргүй орлоготой хаамт бүртгэсэн нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгуулагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн заавар”-ын 2.10 заалттай нийцэхгүй, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул аудитын явцад залруулсан.

Аудитаар нийт 5,009.6 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 4,202.2 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 807.4 мянган төгрөгийн 3 зөвлөмжийг өглөө.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 5,009.6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 27,624.0 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### 3.1 Төлбөрийн акт

*<u>Илрүүлэлт 1:</u>*

Мэргэжлийн зэргийн нэмэгдлийг 3 багшид илүү тооцож олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" заалттай нийцэхгүй, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул төлбөрийн акт тогтоов.

*<u>Илрүүлэлт 2:</u>*

Мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, багш, ажилтны мэргэжлийн хөгжлийг хангах, зөвлөн туслах чиг үүрэгтэйгээр ажилладаг аймгийн Хөвсгөл аймгийн БШУГ-ын мэргэжилтэн Дүүрэнбилэгийн дансанд багшийн хөгжлийн зардлаас сургалтын төлбөр шилжүүлсэн байгаа нь Боловсролын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.5-д “Аймаг, нийслэлийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтэс харьяа нутаг дэвсгэртээ дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: өмчийн хэлбэр үл харгалзан бүх түвшний боловсролын сургалтын байгууллагад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, багш, ажилтны мэргэжлийн хөгжлийг хангах, зөвлөн туслах;”, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;” заалттай нийцэхгүй, “нийцсэн ба зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул төлбөрийн акт тогтоов.

### 3.2 Албан шаардлага

Шилэн дансны цахим хуудсанд 59,360.8 мянган төгрөгийн 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 2 гүйлгээ, 105,237.2 мянган төгрөгийн 7 гүйлгээ, хөрөнгө, мөнгө, өр төлбөр үүсгэхтэй холбоотой 50,547.5 мянган төгрөгийн 11 шийдвэр мэдээлээгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;", 6.4.5."цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" 6.4.8."бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө

зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;" заалттай нийцэхгүй, "нийцсэн ба зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байх тул албан шаардлага хүргүүлэв.

### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

*Илрүүлэлт:*

Тус сургуулийн үндсэн хөрөнгөнд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 26 нэр төрлийн 18,446.6 мянган төгрөгийн 74 хөрөнгө бүртгэлтэй байгаа нь УСНББОУС-17 "Үндсэн хөрөнгө"-ийн параграф 67, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалт болон ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7 дугаар бүлгийн 7.1 заалттай тус тус нийцээгүй, "үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж*:

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг ОНӨГ-т хүргүүлэн шийдвэрлүүлж, үр дүнг нягтлан бодох бүртгэлд тусгах

2. Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал

*Илрүүлэлт:*

Сургуулийн цахим хэрэглээний зардлаас нягтлан бодогч, нярав 315.0 мянган төгрөгийн дата авсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах;" заалт, БШУС-ын 2019 оны А/170 дугаар тушаалын гуравдугаар хавсралтаар батлагдсан "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, хуваарилах заавар"-т заасан зориулалт, арга хэмжээтэй нийцэхгүй "үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Төсвийг батлагдсан зориулалт, арга хэмжээний дагуу, холбогдох хууль, журам, зааварт нийцүүлэн зарцуулж байх.

3. Хөрөнгийн үнэлгээтэй холбоотой асуудал

Нягтлан бодох бүртгэлд малыг үнэ зах зээлийн үнээс хэт доогуур үнээр үнэлж бүртгэсэн нь УСНББОУС-12 "Бараа материал"-ын 16-р параграф, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3."холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалттай нийцэхгүй, "үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Малыг зах зээлийн үнэд ойртуулан үнэлж, нягтлан бодох бүртгэлд тусгах

# 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

## Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Сурах бичгийн түрээсийн авлага бүртгээгүй | 1 | 259.6 | 1 | 259.6 | | | | | | | | |
| Олон улсын байгууллагаас өгсөн хөрөнгийг хандивын орлогоор бүртгээгүй | 1 | 25224.4 | | | 1 | 25224.4 | | | | | | |
| Дүн | 2 | 25484.0 | 1 | 259.6 | 1 | 25224.4 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Цалингийн нэмэгдлийг илүү тооцож олгосон | 1 | 1402.2 | 1 | 1402.2 | | | | |
| БШУГ-ын мэргэжилтэн өөрийн чиг үүргийн дагуу хийсэн сургалтад төсвөөс төлбөр авсан. | 1 | 2800.0 | 1 | 2800.0 | | | | |
| Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгө нягтлан бодох бүртгэлд бүртгэлтэй байна. | 1 | - | | | | | 1 | - |
| Зардлын зориулалт, арга хэмжээнд нийцүүлж зарцуулаагүй байна. | 1 | 315.0 | | | | | 1 | 315.0 |
| Малын үнийг хэт доогуур үнээр үнэлсэн | 1 | 492.4 | | | | | 1 | 492.4 |
| **Дүн** | **5** | **5009.6** | **2** | **4202.2** | | **-** | **3** | **807.4** |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлого, зарлага болон шийдвэр дутуу мэдээлсэн | 1 | 215,145.4 | | | 1 | 215,145.4 | | |
| **Дүн** | **1** | **215,145.4** | | | **1** | **215,145.4** | | |

## 5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| | **НИЙТ** | **1** | **1** | | | **1** | | | |

# ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
# АКТ

2024 оны 02 сарын 26 өдөр №41/А2970439/ХӨА-2024/203/НА-СТА-ТШЗ Мөрөн сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. **Үүнд:**

Багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих болон боловсролын стандарт сургалтын хөтөлбөр арга хэмжээний батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргахдаа мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, багш, ажилтны мэргэжлийн хөгжлийг хангах, зөвлөн туслах чиг үүрэгтэй, аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын Заах аргын нэгдлийн хэлтсийн дарга Я.Дүүрэнбилэгтэй гэрээ байгуулан, сургалт хийлгэж 2,800,000 /хоёр сая найман зуун мянга/ төгрөгийн төлбөр төлсөн байна.

Энэ нь Боловсролын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.5-д "Аймаг, нийслэлийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтэс харьяа нутаг дэвсгэртээ дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: өмчийн хэлбэр үл харгалзан бүх түвшний боловсролын сургалтын байгууллагад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, багш, ажилтны мэргэжлийн хөгжлийг хангах, зөвлөн туслах", Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаал "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах чиг үүрэгтэй албан хаагчид гэрээгээр төлсөн төлбөр 2,800.000 /хоёр сая найман зуун мянга/ төгрөгийг Боловсрол, шинжлэх ухааны газрын Заах аргын нэгдлийн хэлтсийн дарга Я.Дүүрэнбилэгээс гаргуулж Хөвсгөл аймгийн Төрийн сан дахь 100170000955/Хө.Бусад нэр заагдаагүй орлого/ тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар[1]т нотлох баримтын хамт ирүүлэхийг Тосонцэнгэл сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал О.Даариймаа, нягтлан бодогч Ц.Баасанжаргал нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

"ИХЭР МӨРӨН АУДИТ"ХХК
ЗАХИРАЛ Б.МЯДАГМАА

[1] Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын байр, А корпус, 3 давхар, 303 тоот

6724020133

# ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
# АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 26 өдөр    № 25/A2270439/ZAA-2024/203/HA-CIIIA-III ш3    Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Тайлант хугацаанд байгууллагын шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний 164,597,980 (нэг зуун жаран дөрвөн сая таван зуун ерэн долоон мянга есөн зуун ная)-н төгрөгийн 9 мэдээлэл мэдээлээгүй, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн 50,547,400 (тавин сая таван зуун дөчин долоон мянга дөрвөн зуун)-н төгрөгийн 11 мэдээлэл мэдээлээгүй.
2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д *"тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх"*, 6 дугаар зүйлийн 6.4. "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;" гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т "*Аудитаар илэрсэн алдаа зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй*", 4.2.1.11-т "*хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал нь албан шаардлага өгөх нөхцөл болно*" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг тогтоосон хугацаанд бүрэн байршуулж, ил тод байдлыг хангаж, илэрсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 20-ны дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар[1]т ирүүлэх;
2. Цаашид гарсан алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал О.Даариймаа, нягтлан бодогч Ц.Баасанжаргал нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР    А.ЭРДЭНЭБААТАР

"ИХЭР МӨРӨН АУДИТ"ХХК
ЗАХИРАЛ    Б.МЯДАГМАА

[1] Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын байр, А корпус, 3 дугаар давхар, 303 тоот

6724030086

# ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
# АКТ

2024 оны 09 сарын 26 өдөр № 46/12270439/ХӨА-2024/203/НА-СПА-ТПШЗ Мөрөн сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 3 багшид мэргэжлийн зэргийн нэмэгдлийг зөрүүтэй тооцоолж 1,402,156 /нэг сая дөрвөн зуун хоёр мянга нэг зуун тавин зургаа/ төгрөгийг илүү олгосон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэж заасныг зөрчсөн ба "үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т *"Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно"*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.3. *"цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон"* гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү тооцож олгосон цалин хөлс 1,402,156 /нэг сая дөрвөн зуун хоёр мянга нэг зуун тавин зургаан/төгрөгийг хавсралтад заасан нэр бүхий ажиллагсдаас суутган тооцож Хөвсгөл аймгийн төрийн санд байрших 100170000955 тоот /Хө. Бусад нэр заагдаагүй орлого/ дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар[1]т нотлох баримтын хамт ирүүлэхийг Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал О.Даариймаа, нягтлан бодогч Ц.Баасанжаргал нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

"ИХЭР МӨРӨН АУДИТ"ХХК ЗАХИРАЛ Б.МЯДАГМАА

[1] Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8 дугаар баг, аймгийн ЗДТГ-ын байр, А корпус, 3 давхар, 303 тоот

6724020148

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын
2024 оны 02 дугаар сарын 26 –ны өдрийн
46/А9970439/ТӨА-2024/203/НА-СМА-ТИЦЗ
төлбөрийн актын хавсралт

172009000 005

## ТӨЛБӨРИЙН ЖАГСААЛТ

/төгрөгөөр/

| д/д | Нэрс | Илүү олгосон цалин хөлс |
|---|---|---|
| 1 | Н.Баттөр | 474,924.00 |
| 2 | А.Батбаяр | 452,308.50 |
| 3 | Н.Бадамцэцэг | 474,924.00 |
| | **Дүн** | **1,402,156.50** |

oooOooo